

ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГҮЙСГЭХ ӨГҮҮЛБЭР  
ТӨЛӨӨЛӨХ ХЭЛБЭР БУЮУ “PRO-FORM”-ООР ИЛРЭХ НЬ  
Pro-forms of negative sentences in modern Mongolian

Д.Энхжаргал\*

**Товч агуулга:** Олон хэлний хэв шинжийн судалгаанд үндэслэн орчин цагийн монгол хэлний үггүйсгэх өгүүлбэрийг төлөөлөх хэлбэрийг авч үзсэн болно.

**Түлхүүр үг:** үггүйсгэгч, үйлийн төлөөлөл, өгүүлбэрийн төлөөлөл

1. Олон хэлний хэв шинжийн судлал дахь “Pro-form” -ийн ойлголт

Төлөөлөх хэлбэр (pro-form) нь тухайн хам бичвэрт үг, хэлц, гишүүн өгүүлбэр эсвэл бүтэн өгүүлбэрийн утгыг нөхөж тэдгээрийг орлодог үг болон илэрхийллийн нэг төрөл юм. Тэдгээр нь тухайн илэрхийллийг давтахаас зайлсхийх зорилгоор хэрэглэгддэг. Төлөөлөх хэлбэрийг олон хэлний хэв шинжийн судлалд Paul Schachter (1978), Giuliano Bernini, Paolo Ramat (1996, 89-90), Hadumod Bussman (2006:950), Paul Schachter, Timothy Shopen (2007: 22-60), Jack C. Richards & Richard Schmidt (2002: 426) нарын зэрэг судлаачид судалсан байна.

**Төлөөлөх хэлбэр** (pro-form) бидний судалгаанд өгүүлбэр дэх үйл үгийг, эсвэл тухайн хам бичвэрт бүтэн өгүүлбэрийг орлож буйгаараа холбоотой. Хамгийн нийтлэг хэрэглэгддэг төлөөлөх хэлбэрийн төрөл нь төлөөний үг буюу *pronoun* бөгөөд өгүүлбэрт нэр болон нэрийн нийлэмжийг орлодог байна. Schachter (1978) дараах жишээнд буй налуу үгсийг төлөөлөх өгүүлэхүүн (pro-predicate) хэмээн тодорхойлсон байна. Тухайлбал,

Англи. Jack fell down, but Jill *didn't*

‘Жэк сэтгэлээр унасан байна, харин Жил үгүй байна.’

Jill isn't crying, but Jack *is*

‘Жил уйлаагүй байна, харин Жэк уйлж байна.’

Гэвч үгийн аймгийн хүрээнд л тодорхойлох нь хангалттай биш хэмээн Paul Schachter, Timothy Shopen (2007: 22-60) нар үзжээ. *Pronoun, pro-verbs, pro-adjectives, pro-adverbs, interrogative pro-forms* (Paul Schachter, Timothy Shopen, 2007:31) зэрэг өгүүлбэрийн гишүүдийг төлөөлөх төдийгүй тэдгээрээс илүү том нэгж, тухайлбал, гишүүн өгүүлбэр *pro-clause*, өгүүлбэрийг төлөөлөх *pro-sentence* (Giuliano Bernini, Paolo Ramat 1996:89, Paul Schachter, Timothy Shopen, 2007:31) хэлбэр байж болохыг судалгаандаа авч үзсэн байна.

**Pro-verb** буюу үйл үгийг төлөөлөх хэлбэр нь үйл үг эсвэл үйлийн нийлцийг орлодог байна. Тухайлбал, англи хэлний *do*. Мандарин хятад хэл аялгуунд *lai* ‘do it’ (түүнийг хий), *zemme* ‘do this’ (үүнийг), *nemme* ‘do that’ (тэрийг хий) зэрэг *pro-verb* байдаг ба нийтлэг хэрэглэгддэг нь *lai* юм. Тухайлбал,

*Ni buhui xiu zhe jigu, rang wo lai*

you know.how.neg repair this machine let I do. It

‘Та энэ машиныг яаж засахыг мэдэхгүй, надаар хийлгэ.’ (Timothy Shopen, Vol I, 2007:33)

**Pro-adjective** буюу хүртээл нэрийг төлөөлөх үг нь тэмдэг нэр эсвэл тэмдэг нэрийн үүргээр орж буй илэрхийллийг орлодог. Франц хэлэнд *le* нь тэмдэг нэрийг орлоно. Тухайлбал,

Jean est grand, mais je ne *le* suis pas

Jean is tall but I neg pro.adj am not

‘Жонн өндөр, харин би тийм биш.’

**Pro-adverb** буюу дайвар үгийг төлөөлөх үг нь дайвар үгийг эсвэл дайвар үгийн үүргээр орж буй илэрхийллийг орлоно. Англи хэлний *thus* эсвэл *akan*<sup>1</sup> хэлний *see* (үүнчлэн), *saa* (ийм маягаар) зэрэг үг дайвар үгийг төлөөлдөг. Тухайлбал,

*Menoa no see, na eno nso noa no saa*

I. cook it this. way, and he too cooks it that. way

‘Би үүнийг ингэж чанадаг, тэр ч бас ийм маягаар чанадаг.’

**Interrogative pro-forms** буюу асуух үгийн төлөөлөх хэлбэрүүд мөн байна. Англи хэлний *who*, *what*, *where*, *when* гэх мэт асуух үгс асуух өгүүлбэрийн эхэнд хэрэглэгддэг ба асуух үгийн хэлбэрүүд үгийн бүх аймагт хамаатай. Тухайлбал, англи хэлэнд *who*, *what* гэх мэт асуух төлөөний үгс (interrogative pronouns), асуух

\* МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш, докторант

<sup>1</sup> Акан (Akan) Нигер Конгийн хэлний бүлгийн хэл, Ква хэл аялгуунд хамаардаг.

Д.Энхжаргал

дайвар үг (interrogative adverbs): *where, when*, асуух ялгац (interrogative articles) *which* in *which book* гэх мэт байна.

**Pro-clause** буюу гишүүн өгүүлбэрийг төлөөлөх хэлбэр. “Pro-clause”-ийн нийтлэг төрөл нь лавлах асуулт. Тухайлбал, *Англи хэлний ор бүхий асуултууд (Is it raining or not?)*

Хауса<sup>2</sup> хэлний

Ana ruwa, ko?

one. is rain or

‘Бороо орж байна уу, үгүй юу?’

Гишүүн өгүүлбэрийг төлөөлөх (pro-clause) өөр нэг төрөл нь англи хэлний *so, not* хэлбэр. Жишээлбэл,

John says that it will rain, but I don't think so

‘Бороо орно хэмээн Жонн хэлсэн, харин би тэгж бодохгүй байна.’

John says that it will rain, but I think not

‘Бороо орно хэмээн Жонн хэлсэн, харин би үгүй гэж бодож байна.’

*So* болон *not* нь энэ тохиолдолд *I don't think that it will rain, I think that it won't rain.* гэсэн өгүүлбэрүүдийг төлөөлж байна.

**Pro-sentence** буюу өгүүлбэрийг төлөөлөх хэлбэр гэж тухайн хам бичвэрээс бүтэн өгүүлбэрийн агуулгыг нөхөж, бүтэн өгүүлбэрийг орлодог үг эсвэл илэрхийллийг хэлнэ.

Өмнөх хам бичвэрт буй илэрхийллийн нэгэн адил илтгэх бүрдүүлбэр бүхий бүтэн өгүүлбэрийг төлөөлж чадах **yes, no** хэлбэрийн илэрхийллүүдийг (Giuliano Bernini, Paolo Ramat 1996, Paul Schachter, Timothy Shopen, 2007) *pro-sentence* хэмээн үздэг. Англи хэлний *yes, no, okay, amen* зэрэг нь нийтлэг төлөөлөх өгүүлбэр (common pro-sentences) хэмээн тооцогддог байна. “Does Mars have two moons?”, өгүүлбэрийн хариулт “Yes” нь “Mars has two moons.” хэмээн ойлгогдоно. Заримдаа аялга үгс өгүүлбэрийг төлөөлөх нь байна. -Is it raining?, асуултад -Yes хэмээн хариулах нь *It's raining гэсэн өгүүлбэр, -No* нь “It isn't raining” гэсэн өгүүлбэртэй тэнцэнэ.

## 2. Орчин цагийн монгол хэлний үгүйсгэх өгүүлбэр төлөөлөх хэлбэрээр илрэх нь

Өгүүлбэрийг үг болон бусад илэрхийллүүд төлөөлөх хэв шинж нь өгүүлбэрээс дээш түвшинд буюу өгүүлэмжийн (discourse) түвшинд илэрнэ. Энэ нь тухайн хам бичвэр, ярианы хам орчноос хамааралтай. Орчин цагийн монгол хэлэнд төлөөлөх өгүүлбэрийг (pro-sentence) судлаачид үгүүлбэр үг (Ш. Лувсанвандан 2000), жинхэнэ бус аялга үг-өгүүлбэр (М. Базаррагчаа, 1987, Б. Пүрэв-Очир, 2001, Д. Төмөртоогоо ба бусад 2004) зэргээр нэрлэдэг байна. Эрдэмтэн Ш. Лувсанвандан (2000:82-83) “Тийм, тэгнэ, үгүй, биш” гэсэн үг дан дангаараа үгүүлбэрийн үүрэг гүйцэтгэж хэрэглэгдсэнийг үгүүлбэр үг гэнэ” хэмээн үзээд дараах жишээнүүдийг тагжээ.

1. -Та өнөө орой манайд очих уу? -Тэгнээ (өнөө орой танайд би очно)  
-Энэ танай ном уу? -Тийм (энэ миний ном)  
-Энэ танай морь мөн үү? -Мөн (энэ манай морь)
2. -Та өнөө орой манайд очих уу? -Үгүй (би өнөө орой танайд очихгүй)  
-Энэ таны морь биш биз? -Биш (энэ миний морь биш)
3. -Та өнөө орой манайд очоорой. -Заа. Би өнөө орой танайд очъё.

Эрдэмтэн М. Базаррагчаа (1987:278) “Монгол хэлний аялга үг-өгүүлбэрийг дараах байдлаар ангилжээ. Үүнд:

А. *Жинхэнэ аялга үг-өгүүлбэр*: 1. Сэтгэлийн хөдөлгөөн илтгэсэн (-аа-ээ-өө-оо-ий, ай-эй-ой, тий тий-тай тай). 2. Уриалж дуудсан: а) хүнд: хүүш, чиш, уухай, ухай б) мал адгуусанд: хааяд, хаа, хөж, гуруй, чаа, мяу

Б. *Жинхэнэ бус аялга үг-өгүүлбэр*:

1. *Сэтгэлийн хөдөлгөөн илтгэсэн* (хөөрхий, зайлуул, чааваас, ашгүй, гялай, Сайхан аа, халаг, хайран, золгүй еэ, азтай яа, аргагүй, бүү үзэгд, баяртай, гялайлаа)

2. *Уриалан дуудсан* (Галлаад! Марш! Алхаад! Давшаад! Май, бүүвэй, ээжээ! Чимээгүй! Дуугай! Ац, аль! харав уу! та минь! барууншаа!)

3. *Зөвшөөрсөн буюу баталсан* (Мөн, тийм, тэгнэ, болно, за, зүгээр, нээрээ /н/, тэр дээ, энэ дээ! яахав, цод, мад)

4. *Эс зөвшөөрсөн буюу үгүйсгэсэн* (Биш, үгүй, тийм биш, болохгүй, тэгэхгүй, дуу! байз! аяд! горьгүй, хай, хаанаас даа, худал аа! хэрэггүй, дэмий гэх мэт) хэмээн ангилсан байна.

Эрдэмтэн судлаач Б. Пүрэв-Очир (2001:207) монгол хэлний өгүүлбэрийг бүтэц, бүтэц бус хэмээн ангилаад бүтэц өгүүлбэрт нэрийн ба үйлийн бүрдүүлбэртэй өгүүлбэрийг багтааж, бүтэц бус өгүүлбэрт нэрийн ба үйлийн бүрдүүлбэргүй өгүүлбэрийг оруулсан байдаг. Бүтэц бус өгүүлбэрийг дотор нь жинхэнэ аялга үг-өгүүлбэр (Бүүвэй бүүвэй, Халхай халхай), жинхэнэ бус аялга-үг өгүүлбэр (Тийм тийм. Үгүй, Биш, За)<sup>3</sup> хэмээн ангилжээ. Б. Пүрэв-Очир (2001:215): “Нэг талаар “гишүүлбэргүй өгүүлбэр” гэж болмоор, нөгөө талаар хэлэхүйн өгүүлбэрийн энэ хэв шинжийг бүтэц бүрдүүлбэрээс нь үзвэл хэлбэр-бүтцийн хувьд өгүүлбэрийн тийм ийм гишүүнээс бүтсэн гэх аргагүй, харилцах төвшинд тухайн өгүүлбэрийн хэлзүйн цөм бүрдүүлэгч болоод дэлгэрүүлсэн дагуул бүрдүүлэгчийг хоёуланг нь задлах аргагүй болтол нь “хураасан”, “төлөөлж хэлсэн”, “нэгтгэн ерөнхийлсөн” мэт маш өвөрмөц бүтэцтэй юм” хэмээн дүгнэжээ.

<sup>2</sup> Хауса (Hausa), Афроазийн хэлний бүлгийн хэл


<sup>3</sup> Б. Пүрэв-Очир (2001) Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй 1, УБ, 207-р тал

Бид орчин цагийн монгол хэлний жинхэнэ аялга үг-өгүүлбэр, жинхэнэ бус аялга-үг өгүүлбэрийг нь өгүүлбэрийг төлөөлж буй шинжээр нь төлөөлөх өгүүлбэр (pro-sentence) хэмээн үзэж байна. “алга”, “биш”, “үгүй” зэрэг үгүйсгэгчүүд үгүйсгэх өгүүлбэрт үйлийн бүлгийг орлож, үйл үгийн үүргээр хэрэглэгдэхийн зэрэгцээ бүтэн өгүүлбэрийг төлөөлөх чадвартай хэмээн үзэж байна.

## 2. 1. Үгүйсгэгч өгүүлбэрт үйлийн бүлгийг төлөөлөх (pro-verb)

### 2.1.1. “Алга” үгүйсгэгч өгүүлбэрт үйлийн бүлгийг төлөөлөх

“АЛГА” үгүйсгэгч “байхгүй, оршихгүй” гэх мэт үйл үгсийг өгүүлбэрт орлоно. Цаашилбал, харагдахгүй, үзэгдэхгүй, бараагүй, сураггүй зэрэг үгсийг өгүүлбэрт орлох боломжтой хэмээн үзэж байна. Х-штрихийн онолын (Noam Chomsky 1988, Jackendoff R.S. 1972) үүднээс авч үзвэл “алга” нь с-command-д үйл үгийн бүлгийг орлоно гэсэн үг.




Төлөөлөх хэлбэрийн онол ёсоор “алга” нь үйлийн төлөөлөл (pro-verb) болж чадна. Өгүүлбэрийн хэв шинжийн хувьд **SO+Neg=SO+ALGA** хэв шинжид хамаарна. Уран зохиолын жишээ баримтаар харуулъя. Нарийн бичгийн дарга бүсгүй харилцуурыг авсан боловч хэсэг хугацаанд чимээ алга. (Г. Батаа, Бундангийн ноён), Өнөөх дууч хүү алгаа. (З. Баттулга Уяхан замбуутив), Ер нь чамтай ярих хэрэг алга! (Ц. Дамдинсүрэн, Бух Гомбо), Гэтэл чамд янаг хайрын сэтгэл алга! (Ц. Дамдинсүрэн, Чемодантай юм), Одоо цагт чинь хатуужихаас дээр юм алга. (Д. Намдаг, Шинэ зам), Дуртай хүнд эдлүүлж байдаг бие надад алга. (Ч. Лодойдамба, Тунгалаг тамир) гэх мэт олон жишээг дурдаж болно.

Энэ хэв шинжид SOV-ын/-ийн NP+Neg V =SO+V-ын/-ийн NP+ALGA хэлбэртэй өгүүлбэр мөн хамаарна. С-command-д үйлийн бүлэг “үйл үг+харьяалахын тийн ялгалын нөхцөл+алга” гэсэн нийлмэл бүтэцтэй байх боломжтой. Тухайлбал, Ажил хийж ачит ээж, амраг хань, бор гэдсээ тэжээнэ гэхэд итгэхийн арга алга. (Г.Дүйнхэржав, Амин дэнс), Тэглээ гээд эцгийнх нь үгийн нууцыг хэлчихийн зориг алгаа. (З. Баттулга Уяхан замбуутив) гэх мэт болно.

### 2. 1.2. “ҮГҮЙ” үгүйсгэгч өгүүлбэрт үйлийн бүлгийг төлөөлөх (pro-verb)

“Үгүй” нь үгүйсгэгчийн үүргээр орж өгүүлбэрийг үгүйсгэхийн зэрэгцээ, дангаараа үйлийн бүлгийг орлож чадна. “Үгүй” нь “алга”-ын адил өгүүлбэрт байхгүй, оршихгүй гэх мэт үгсийг орлоно. Өгүүлбэрт үйлийн бүлгийг төлөөлж буй “үгүй” бүхий өгүүлбэр дараах бүтэцтэй.



Уран зохиолын жишээгээр: Хумка үг олон үгүй. Чонос үг Хумка үгэнд үгүй. Жад гэж Хумка үгэнд үгүй. Нум гэж Хумка үгэнд үгүй. Сал гэж Хумка үгэнд үгүй. Олон үг үгүй. (Б. Ринчен, Заан Залуудай), Хөнөөл хяхал чамд хүргэх хэн ч үгүй. (Д. Нацагдорж, Сараа), Ойдов:-Тэднээс тийм үг ер нь хэлсэн зааварласан зүйл огт үгүй. (Ши. Аюуш, Яг арван найм) гэх мэт болно.

### 2. 1.3. “Биш” үгүйсгэгч үйлийн бүлгийг төлөөлөх (pro-verb)

Үүнийг SO+pro-verb= SO + БИШ хэмээн томъёолж болно. Энэ тохиолдолд биш нь үйлийн бүлгийг орлох ба *pro-verb* болж байна. Судлаач Б. Пүрэв-Очир “Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй 2” (УБ, 2000) бүтээлдээ:

“Энэ нь биш, тэр нь таарч байна.

**Чинийх биш**, Батын ном юм.

**Чамайг биш**, намайг явуулна.

**Доржид биш**, Батад өгөв.

**Батаас биш**, Доржоос асуув.

**Доржтой биш**, Баттай тоглов.

**Доржоор биш**, Батаар яриулав.

**Дорж руу биш**, Бат руу харав.г.м-ээр хэлхэцийн нэг тал нь үгүйсгэсэн харьцаа зааж, нөгөө тал нь түүнтэй ерөнхийдөө эсрэгцсэн байдалтай, нотлол хэлбэртэй байгаа, нөгөө талаар бус, биш нь үйл үгийн утга үүргээр орж, өмнөх нэр үгээ нэрлэх, харьяалах, заах, өгөх орших, гарах, үйлдэх гэх мэт бүх тийн ялгалаар захирч байгаа юм шиг хэв шинж харагдаж байна” хэмээн тайлбарласан байна. Бид судлаачийн “бус, биш нь үйл үгийн утга үүргээр” орж байна гэсэнтэй санал нийлж байна. Бид дээрх жишээнд буй “биш”-ийг үйлийн бүлгийг орлож буй үйлийн төлөөлөл үг (pro-verb) хэмээн үзээд дээрх өгүүлбэрүүдийг

**Энэ нь таарахгүй**, тэр нь таарч байна.

**Чиний ном биш**, Батын ном юм.

**Чамайг явуулахгүй**, намайг явуулна.

**Доржид өгөхгүй**, Батад өгөв.

**Батаас асуусангүй**, Доржоос асуув.

**Доржтой тоглосонгүй**, Баттай тоглов.

**Доржоор яриулсангүй**, Батаар яриулав.

Дорж руу харсангүй, Бат руу харав.” гэсэн зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрүүдийг хураангуйлсан хэлбэрүүд байна гэж үзэж байна. Эдгээр зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрүүдийн эхний өгүүлбэрийн үйл үгийн бүлгийг “биш” нь дангаараа орлож, өгүүлбэрийг үгүйсгэх утгатай болгож байна хэмээн тооцож байна. Бид үүнийг уран зохиолын жишээгээр нотлон харуулъя. Чиний тайван нойрсдог цаг биш. (Г. Батаа, Бундангийн ноён), Үхэр холдоогүй цагт ус санах хэрэг биш. (Б. Ринчен, Заан Залуудай), Энэ бол амьтан биш шавар мөн. (Ц. Дамдинсүрэн, Хэнз хурга), Сандаг: -Сэмжид гэдэг чинь, учиргүй хүн бүрийн төлөө чихээ тавьж явдаг ч хүн биш шүү. (Л. Ванган, Эмч нар), Энэ хоёр Заяын хүрээний унаган шавь биш. (Ч. Лодойдамба, Тунгалаг тамир) гэх мэт болно.

## 2.2. Орчин цагийн монгол хэлнээ үгүйсгэх өгүүлбэрийг төлөөлөх хэлбэрүүд (pro-sentence)

Өгүүлбэрийг ганц үг биш, хэлц үгс болон бусад илэрхийллүүд төлөөлөх чадвартай. Бид энд зөвхөн үгүйсгэх утга бүхий өгүүлбэрийг үгүйсгэх үүрэгтэй үгүйсгэгчүүд төлөөлөх хэв шинжийг авч үзлээ. Бидний судалгаагаар орчин цагийн монгол хэлнээ үг үгүйсгэх өгүүлбэрийг төлөөлөх дараах хэлбэрүүд байна. Үүнд:

1. Үгүйсгэгчүүд: алга, биш, үгүй, битгий
2. Үгүйсгэх утгатай үйл үгс эсвэл үгүйсгэгч бүхий үйл үгс
3. Үгүйсгэх утгатай хэлц үгс: үхсэн хойноо, гонж, яалаа гэж, хаанаас
4. Үгүйсгэн захирахууд хэрэглэгддэг зарим үгс, хэлц үгс: дуу!, чиш! гэх мэт болно.

### 2.2.1. Үгүйсгэгчүүд үгүйсгэх өгүүлбэрийг төлөөлөх нь

#### 2.2.1.1. “алга” үгүйсгэгч өгүүлбэрийг төлөөлөх нь

“Алга” үгүйсгэгч өгүүлэмжийн түвшинд бүтэн өгүүлбэрийг төлөөлж, тухайн хам бичвэрт үгүйсгэх утгатай өгүүлбэрийг төлөөлнө. Тухайлбал,

Асуулт: Та нарын дунд монгол хүн байна уу?

Хариулт: Алга.

#### 2.2.1.2. “БИШ” үгүйсгэгч өгүүлбэрийг төлөөлөх нь (pro-sentence)

Орчин цагийн монгол хэл (Д. Төмөртоогоо ба бусад, 2004:264) хамтын бүтээлд: “Монгол хэлний жинхэнэ бус аялга үг-өгүүлбэр нь **Тийм, Тийм дэг, Үгүй шүү, Мөн дөө** гэх мэтээр холбосон зэргэлдээх өгүүлбэрийн агуулга хэлбэрийг бүхэлд нь төлөөлж баталсан эсвэл төлөөлж үгүйсгэсэн харьцаатай байх бөгөөд хүүрнэх, асуух, анхааруулах өгүүлбэрийн аялгатайгаар бүтсэн байж болно. Жишээ нь:

-Та ямар үндэстэн бэ?

-Таа л даа.

-Араб гэж тэр хүүхний хэлэхэд Дармаев толгой сэгсрэв.

-Тэгвэл турк.

-**Биш.**

-Казак.

-**Биш.**

-Энэтхэг.

-Биш гэж хэлэв” хэмээн үзжээ.

Бид энд буй “биш”-ийг бүхэл бүтэн үгүйсгэх өгүүлбэрийг төлөөлж чадах төлөөлөх өгүүлбэр (pro-sentence) хэмээн үзэж байна. Төлөөлөх өгүүлбэр (pro-sentence) нь зөвхөн үгүйсгэх утга бүхий нэг үг биш бас өгүүлбэрийг төлөөлсөн үгүйсгэгч бүхий үйл үг болон бусад илэрхийллүүд байх боломжтой. Тухайлбал,

Сэмжид:- ...Тэр өвгөн чинь уг нь эмч хүн үү?

Сандаг:- **Биш ээ галч**, үгүй яагаав дээ, нөгөө найзтай өвгөн. (Л. Ванган, Эмч нар)

- Орой болтол хэдий хэр мөд харуулдах вэ гэж Лавай тэнсэх маягаар асуулаа.

-Их бишээ гэж Жү овогт гараа алдлаад ... (Б.Мандир, Нөмгөн эр)

## 2. 2.1.3 “ҮГҮЙ” үгүйсгэгч өгүүлбэрийг төлөөлөх (pro-sentence)

### 2. 2.1.3.1. “ҮГҮЙ” үгүйсгэгч гишүүн өгүүлбэрийг төлөөлөх нь

“Үгүй” үгүйсгэгч гишүүн өгүүлбэрийг мөн төлөөлж, төлөөлөх гишүүн өгүүлбэр (pro-clause)-ийн үүргийг гүйцэтгэж болно. Тухайлбал, Хуагчин эмгэн өгүүллүүн: <<Гэр нь ойр байна. Тэмүжиний бий үгүйг би мэдэхгүй, би хойд гэрээс гарч ирэв>> гэв. (МНТ, 100-р зүйл) Эл тохиолдолд “үгүй” нь гишүүн өгүүлбэрийг төлөөлж, <<Тэмүжиний бий үгүйг би мэдэхгүй, би хойд гэрээс гарч ирэв>> өгүүлбэр “Тэмүжиний байгаа болон Тэмүжиний байхгүйг би мэдэхгүй, би хойд гэрээс гарч ирэв” гэсэн өгүүлбэр байна.

### 2. 2.1.3.2. “ҮГҮЙ” үгүйсгэгч өгүүлбэрийг төлөөлөх нь

Орчин цагийн монгол хэлнээ “үгүй” хэмээх үг өгүүлэмжийн хүрээнд бүтэн өгүүлбэрийг орлож буйг харж болно. Тухайлбал, Чулуугаар тоо бодож байсан өвгөн гараа өргөж олны шуугиан намдаагаад, хоёр Дүлхижегээс -Та нар отгоосоо гарахдаа манайхны Цахиурчин отгийнхон дайрна гэж зорин гарсануу?- **Үгүй**. (Б. Ринчен, Заан Залуудай). Эл өгүүлэмжийн “үгүй” хариулт нь “Та нар отгоосоо гарахдаа манайхны Цахиурчин отгийнхон дайрна гэж зорин гарсануу?” гэсэн өгүүлбэрээс нөхөгдөн ойлгогдох “Бид нар отгоосоо гарахдаа манайхны Цахиурчин отгийнхон дайрна гэж зорин гараагүй” гэсэн бүтэн өгүүлбэрийг орлож байна хэмээн бид үзэж байна.

Хүүхдүүдийнхээ юу болох хувь заяатай төрснийг үзүүлсэн үү?

-**Үгүй**. (Д. Цэвэгмид, Соёлын зул бадарсан нь)

Энд буй “Үгүй” хариулт “Хүүхдүүдийнхээ юу болох хувь заяатай төрснийг үзүүлээгүй” гэсэн өгүүлбэрийг орлож байна.

-Хаалгандаа монгол цоож хийх гэж байгаа юм байх даа. -**Үгүй дэгээ**. (Д. Батбаяр, Мэлмий) “Үгүй дэгээ” хариулт “Хаалгандаа монгол цоож хийх гэж байгаа биш байна.” гэсэн бүтэн өгүүлбэрийг төлөөлнө.

Сүхбаатар: -Сүрхий холоос яваа юм байна. Бидэнтэй нийлэхээр ирээ үү?

Дандар:- (цочин) **Үгүй чийш!** (Д. Намдаг, Шинэ зам)

Таньд зовлонгоо ярьж таны амрахад чинь саад болж байна уу даа гэж Дорж гуай хэлэхэд, -**Үгүй, үгүй** Дорж гуай гэж би хариулав. (Ч. Лодойдамба, Хугараагүй ноён нуруу)

Цээсүрэн:-Гал зууханд нэг сандал бий. Эгч нь аваад ирье.

Отгон: **Үгүй, үгүй**. Би суух гээгүй. (Д. Батбаяр, Цөөрөм) гэх мэт олон жишээг дурдаж болно.

### 2. 2.1.4. “Битгий” үгүйсгэгч өгүүлбэрийг төлөөлөх нь

Судлаач Ю. Мөнх-Амгалан, Кан Шин (2014:225) нар “Бүү хэмээх чимэх үг нь биеэ дааж харьцангуй утга төгсгөж чаддаггүй бол битгий нь хойноо үг дагуулалгүй дангаараа хориглох утга илтгэж чадна. Жишээлбэл: Битгий! Одоо болно.” хэмээн үзжээ. Бид ч үүнтэй санал нэг байна. Бид үүнийг өгүүлбэр төлөөлөх нэг хэлбэр байж болно гэж үзэж байна.

### 2.2.2. Үгүйсгэх утгатай үгс өгүүлбэрийг төлөөлөх (pro-sentence)

Бид үгүйсгэх утгын тухай өгүүлж буй тул үгүйсгэгч болон үгүйсгэх үгс өгүүлбэрийг төлөөлөх хэлбэрийг л авч үзэж байна. Үгүйсгэгчүүд өгүүлбэрийг төлөөлөхөөс гадна үгүйсгэх утгатай, үгүйсгэгч бүхий үйл үгс өгүүлбэрийг төлөөлж болно. Тухайлбал, “-Танайд шинээр гарсан толь бичиг байна уу? –Байхгүй” гэсэн өгүүлэмжийн хүрээнд “байхгүй” нь “Манайд шинээр гарсан толь бичиг байхгүй” гэсэн өгүүлбэрийг төлөөлнө.

### 2.2.3.Хэлц нь өгүүлбэрийг төлөөлөх (phrase as a pro-sentence)

Хэлц үгс өгүүлбэрийн утгыг үгүйсгэх хэлбэрийг монгол хэл шинжлэлд судлаач Ж. Бат-Ирээдүй (2009) авч үзсэн байдаг. Үгүйсгэх утгатай хэлц үгс өгүүлбэрийг төлөөлж болохыг бидний судалгаа харуулж байна. Тухайлбал:

Цээсүрэн: -Ганзоригийг гараагүй бол чи өдийд намайг хаячихсан.

Гунгаа: -За **яалаа гэж**. (Д. Батбаяр, Цөөрөм)

“За яалаа гэж” хариулт “Ганзоригийг гараагүй байсан ч би чамайг хаяхгүй байсан” гэсэн өгүүлбэртэй дүйх тул бүтэн өгүүлбэрийг төлөөлж чадна.

Түшиг: -Ийм сайхан ус гарч байна. Чи уух уу. (Чоймболд өгнө.)

Чоймболд:- (зэвүүцэн) **Үхсэн хойноо**. (Д. Намдаг,Тэмцэл)

“**Үхсэн хойноо**” хэлц тухайн хам бичвэрт “-Ийм сайхан ус гарч байна. Чи уух уу” өгүүлбэрээс утга нөхөгдөн “Би тэр тэр сайхан усыг чинь уухгүй” гэсэн бүтэн өгүүлбэрийг төлөөлж байна хэмээн бид үзэж байна.

Цэрмаа: -Би яваад ирэх үү, танай мориор явах уу?

Нямжав: -**Дэмий, дэмий**. (Д. Намдаг,Тэмцэл)

Д.Энхжаргал

“Дэмий, дэмий” хариулт “Чи яваад хэрэггүй” гэсэн утгатай өгүүлбэрийг төлөөлнө.

-Хүүе хоол идээд яваач. -**Зүгээр. Зүгээр.** (Д. Батбаяр, Мэлмий)

Думаа:-Суу, суу, дайптайгаа зэрэгцэж сууж, цай ууж сайхан ярилц л даа.

Гавармаа:-За яршиг, юугаа ярих юм. (Д. Намдаг, Амь ба амьдралын үнэ)

Дээрх жишээ өгүүлбэрүүдэд буй “үхсэн хойноо, дэмий, зүгээр, хаанаас, яршиг зэрэг нь тухайн хам бичвэрт бүтэн өгүүлбэрийг төлөөлж үгүйсгэх утга бүхий pro-sentence болж байна.

#### 2.2.4. Үгүйсгэн захирахууд хэрэглэгддэг зарим үгс, хэлц үгс өгүүлбэрийг төлөөлөх нь

Үгүйсгэн захирахуун хэв шинжид бүтэн өгүүлбэрийг төлөөлсөн зарим үгс, хэлц үгс өгүүлбэрийг төлөөлнө. Тухайлбал,

Гавармаа:-Би түүгээр чинь эмчлүүлэхгүй ээ, та өөрөө эмчлүүл.

Думаа:-**Хош!** Юу гэсэн үг вэ?. (Д. Намдаг, Амь ба амьдралын үнэ)

“хош!” нь тухайн хам бичвэрт “Чи битгий тэгж ярь” гэсэн утгатай өгүүлбэрийг төлөөлнө.

Дариймаа: Тайвшир, битгий хөдөл! Бүү амьсгал!гэхээс өөр юу хэлж чадах юм.

Жав:-**Чиш!** Маргаан уу? ! (Д. Батбаяр, Хайрыг хайрла)

Дээрх өгүүлэмжийн хүрээнд илэрсэн “Чиш!” нь “Та нар чимээгүй бай” гэсэн утгатай өгүүлбэрийг төлөөлнө.

### ДҮГНЭЛТ

Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн утгыг үгүйсгэх хэв шинжүүдийг судлах хүрээнд олон хэлний хэв шинжийн судлал дахь төлөөлөх хэлбэр буюу *pro-form* ойлголтыг авч үзээд дараах дүгнэлтэд хүрэв.

- Өгүүлбэр, өгүүлэмжийн (discourse) түвшинд илэрдэг төлөөлөх хэлбэр (pro-form) нь орчин цагийн монгол хэлнээ хангалттай судлагдаагүй байна. Иймд энэ чиглэлээр судалгаа хийх зайлшгүй шаардлага байна.

- Төлөөлөх хэлбэрийн олон төрлийг бид онолын хэсэгт өгүүлсэн ба эл судалгааны зорилго зөвхөн үгүйсгэх утгатай өгүүлбэрт хандсан тул батлах, асуух зэрэг бусад өгүүлбэрийн төрлийг авч үзсэнгүй. Бид монгол хэлэнд үгүйсгэх өгүүлбэрийн үндсэн хоёр төлөөлөх хэлбэр байна хэмээн үзэж байна.

- 1) Үгүйсгэгч үгүйсгэх өгүүлбэрийн үйлийн бүлгийг төлөөлөх хэлбэр (pro-verb)

- 2) Үгүйсгэгч болон үгүйсгэх утга бүхий бусад илэрхийллүүд үгүйсгэх өгүүлбэрийг төлөөлөх хэлбэр (pro-clause, pro-sentence)

- Эрдэмтэн судлаач Б. Пүрэв-Очирын жинхэнэ бус аялга үг өгүүлбэрийг хоёр ба нэг бүрэлдэхүүнт өгүүлбэрийн аль алинд нь оруулалгүй бүтцийн тусгай хэв маяг болгон үзэх гэсэнтэй санал нийлж байна.

- Бид орчин цагийн монгол хэлний үгүүлбэр үг (Ш. Лувсанвандан, 2000), *жинхэнэ ба жинхэнэ бус аялга үг-өгүүлбэр* (М. Базаррагчаа 1987, Б. Пүрэв-Очир 2001) нь өгүүлбэрийг төлөөлөх хэлбэр буюу pro-sentence мөн хэмээн үзэж байна. Үүнээс үүдэн бид үүнийг олон хэлний хэв шинжийн судлалд хүлээн зөвшөөрөгдсөн төлөөлөх өгүүлбэр (pro-sentence) хэмээх нэр томъёогоор нь нэрлэх санал дэвшүүлж байна.

**Resume.** Pro-sentences are words like English *yes* and *no*, which are used in answering questions, and which are understood as equivalent to affirmative and negative sentences respectively. In the article were considered pro-forms of negative sentences in modern Mongolian.

### Номзүй

Базаррагчаа М (1987) Монгол хэлний өгүүлбэр, УБ

Бат-Ирээдүй Ж (2009) Монгол хэлний үгүйсгэх харьцаа ба түүний илрэх

хэлбэрүүд. “Area and Culture Studies”, Tokyo University of Foreign Studies, №78, 2-13

Бямбасан П. (2006) Монгол хэлний онол, бүтцийн асуудалд, УБ

Гантогтох Г (1987) Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал, ШУА, ХЗХ, УБ

Лувсанвандан Ш (2000) Монгол хэлний үгүүлбэрзүйн асуудлууд, гутгаар дэвтэр, УБ

Төмөртоогод. ба бусад (2004) Орчин цагийн монгол хэл, ред Ү. Ариунболд, УБ

Пүрэв-Очир Б (2001) Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй I, УБ

Пүрэв-Очир Б. (1998) Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй II, УБ

Giuliano Bernini, Paolo Ramat (1996) *Negative Sentences in the Languages of Europe: A*

Typological Approach. Mouton de Gruyter, Berlin/New York, 89-90

Hadumod Bussmann (1998), Routledge Dictionary of Language and Linguistics,

London&New York

Jack C. Richards, Richard Schmidt (2002) Longman dictionary of language teaching and applied linguistics

Jackendoff R.S. (1972) Semantic interpretation in Generative Grammar, Cambridge

Noam Chomsky (1988) The lectures on Government and binding, Foris Publications Holland

Paul Schachter (1978) English proprecates. *Linguistic Analysis* 4, 187-224.

Timothy Shopen (2007) Language typology and Syntactic description, Volume I: Clause structure, second edition, Cambridge University press

Wonsoo Yu (1991) A study of Mongolian Negation, Indiana University